

ХЭНТИЙ АЙМГИЙН ХҮҮХДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ӨМНӨТГӨЛ

Хүүхэд бүрийг эрүүл чийрэг энх мэнд өсгөх, бүх талаар хөгжүүлэх, хамгаалах нь хүний хөгжлийн анхдагч үндэс тул амьдралын эхний үеэс нь л тэдэнд аль болохуйц таатай, сайн орчин нөхцөлийг бүрдүүлж өгөх нь нэн чухал байдаг. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжил хамгаалал нь тэдний өсч торнин амьдарч буй нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалах бөгөөд эрх мэдэл, нөөц баялгийн хуваарилалт ямар байгаагаар тодорхойлогддог билээ.

Бид хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамааран хамгийн хүнд хэцүү байдалд амьдарч буй хүүхдүүдэд эн тэргүүнд анхаарлаа хандуулж, тэгш бус ялгаатай байдлын учир шалтгааныг тодорхойлж, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч болгодог, нийгмийн амьдралд оролцох оролцоог нь боогдуулдаг, үйлчилгээнд хамрагдах боломжийг нь хязгаарладаг хүчин зүйлсийг олж тогтоон арилгах нь хөгжлийн шийдэл юм.

“Хэнтийн хүүхдийн байдал” эмхтгэлийн зорилго нь орон нутагт хүүхдийн язгуур эрх ашиг хэр зэрэг хамгаалагдаж байгааг харуулах, үнэлэх явдал төдийгүй ядуурал, ялгаатай байдлыг арилгах, хот төлөвлөлт, дэд бүтцийн хөгжил, үйлчилгээний хүртээмж зэрэгт хүүхдийн тусгай хэрэгцээг онцгойлон анхаарч, түүнчлэн хүүхэд залуучуудын санал бодлыг шийдвэр гаргахад тусгахад чиглэсэн.

Орон нутгийн бүх хүүхдүүдийн төлөө хийж байгаа ажлын тулгуур зарчим нь эрх тэгш, шударга байдал байх ёстой. Хүүхэдтэй холбоотой тоо баримтыг цуглуулж, дүгнэлт хийх нь хүүхэд төвт бодлогын орчныг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой. Хүүхдүүд багачуудынхаа өнөөгийн болон ирээдүйн сайн сайхан амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төр төрийн бус байгууллага, иргэд олон нийт, гэр бүл эцэг эх зэрэг хүүхдийн амьдралд чухал нөлөөтэй бүх талууд хамтран ажиллаж, “Хүүхдэд ээлтэй орон нутаг”-ийг цогцлоон бүтээх юм.

Хүүхдэд ээлтэй хот төлөвлөлт, хөтөлбөрийг бий болгох нь Хүүхдийн эрхийн конвенцид тусгасан хүүхдийг үл ялгаварлах, эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох эрхийг хангах зарчмуудын тусгал болсон хүний эрхэд суурилсан засаглалын загвар юм. Хүүхдэд ээлтэй орон нутаг хандлага нь орхигдсон бүлгүүдэд нийгэмших боломж олгож, бүх хүүхдэд эрх болон хэрэгцээгээ хангуулж, шийдвэрлүүлэх боломж олгодгоороо эрх тэгш байдлаар хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг юм.

Хүн бүхэн өөрийн хүүхдэд зориулдаг хайр халамж, үүрэг хариуцлагаа бусад хүүхдэд нэгэн адил зориулж чадваас хүүхэд бүр аз жаргалтай, эрүүл энх байх болно.

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Б.ЭНХ-ЭРДЭНЭ

Хүүхдийн өмнө хүлээх бидний үүрэг


Хүүхэд нас бол бүх хүн төрөлхтний сайн сайхан ирээдүй төдийгүй хүний хөгжлийн суурь хүүхэд насанд бүрддэг. Хүүхдийн эрхийн тухай Конвенцид “18 хүртэлх насны хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсон. Хүүхдийн өсөлт хөгжлийг шинжлэх ухааны үүднээс авч үзвэл бага насны хүүхэд ямар нэгэн гачигдалд ороход тэдний хөгжил, чадавхид өөрчлөлт орох төдийгүй энэ нь эргээд улс орны хөгжилд нөлөөлж байдаг.

Хүүхдийн эрхийн тухай Конвенц болон Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд хүлээсэн амлалтуудыг хэрэгжүүлж, хүүхдэд эн тэргүүнд анхаарлаа хандуулан, тэдний амьдралд нөлөөлж буй сөрөг нөлөө, түүний шалтгаан, тархцын хүрээг тодорхойлох нь нэн чухал байна. Хаана амьдарч байгаагаас нь үл шалтгаалан хүүхэд бүрийн эрхийг тэгш хангах нь төрийн үүрэг билээ.

Хүүхдүүдэд шаардлагатай орчин, хамгаалал, үйлчилгээг хүргэж чадаагүйн улмаас хүүхдийн бүтээлч, шинийг эрэлхийлэх хүсэл эрмэлзлэлийг алдагдуулж, эргээд тэдний нийгэм, соёл, эдийн засагт оруулах хувь нэмрийг бууруулж байдаг. Хүүхэд бүрт эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж өгч чадсанаар олон зуун хүүхэд эрүүл саруул өсөн бойжиж, хөгжихийн зэрэгцээ илүү үр бүтээлээр арвин амьдрах боломжтой болох юм.

Бүх хүүхдэд анхаарал хандуулан төсөв хөрөнгө оруулалтыг жигд хуваарилж, нэг хүүхдийн давуу байдал нөгөө хүүхдийн сул дорой байдлыг нуун халхлах боломжгүй болсон цагт л бид бүх хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Хэнтий аймгийн хүүхдийн тоо



Хэнтий аймгийн нийт хүүхдийн тоо 2018 оны суурь үзүүлэлтээр 27314 буюу нийт хүн амын 34,5%, үүнээс охид-50 хувийг эзэлж байна.

Хүүхэд эрүүл эсэн мэнд амьдрах эрхтэй



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ /6-р зүйл/

1. Оролцогч улсууд хүүхдийн амьд явах жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана.



Амьдралын эхний жилүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ хангалтгүй байх нь хүүхдийн үлдсэн амьдралд нөлөө үзүүлдэг.

Хүүхдэд ээлтэй хотод хүүхдийн нарийн мэргэжлийн (шүд, хэл яриа, сонсгол) эмчийн үйлчилгээг амьдран суугаа газрынх нь ойр очиход боломжийн зайтай газарт ойртуулах, төрсний дараах эхний саруудад нярайн гэрийн эргэлт хийх, эмч сувилагчдын ажлын байр, клиник, эмнэлгүүд нь хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн байна.

Тухайлбал хүүхдийн тэрэг орох бололцоотой, хөхөөр хооллох хэсэгтэй, ариун цэврийн өрөө нь хүүхдийн живх солих ширээтэй, бага насны хүүхэд унших номтой байх нь эдгээр эрүүл мэндийн төвүүдийг хүүхдэд ээлтэй болгоход чухал нөлөө үзүүлдэг.

Хүүхдийн хоол тэжээл

Хүүхдийн хоол тэжээлийн дутагдал нь улс орнуудын нийгмийн эрүүл мэндийн гол асуудлуудын нэг хэвээр байсаар байна.

Хоол тэжээлийн хомсдол нь орлого бага, өрхийн гишүүдийн тоо олон, боловсрол нимгэн, ус, хүнс, эрүүл ахуй, эхийн болон хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүрэлцээ муу байх зэрэг ядуурлын үр дагавар юм.



0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /2017-2019-9 сар/ /амьд төрсөн 1000 хүүхдэд/

Аймгийн хэмжээнд нялхасын эндэгдлийн 2019 оны 9 сарын байдлаар 23 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 19,4 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.8 промилоор өссөн ба улс аймгийн дунджаас өндөр байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /2017-2019-9 сар/ /амьд төрсөн 1000 хүүхдэд/

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл нь 2017 онд улсын дунджаас өндөр байсан ба 2018 онд улсын дунджаас буурсан, 2019 оны 9 сарын байдлаар улсын дунджаас өссөн үзүүлэлттэй байна.

Өсвөр үеийнхний эрүүл мэнд



Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ нь тохиромжтой байршилд таатай, аюулгүй орчин бүрдүүлсэн, тохиромжтой цагийн хуваариар ажилладаг, хувийн нууцыг хадгалдаг, мэдээлэл, сургалтын материалаар хангагдсан байхыг хэлнэ. Хүүхэд шүдээ байнга угааж, цэвэрлэж хэвших нь амны хөндийг эрүүл байлгах чухал ач холбогдолтой билээ. ХДХВ/ДОХ, БЗДХ -аас сэргийлэхийн тулд хайр сэтгэлдээ үнэнч байх, тохиолдлын бэлгийн хяналд орохгүй тэвчих, бэлгэвчийг тогтмол

хэрэглэхийг зөвлөдөг. Биеэ өвдсөн үед заавал эмчид үзүүлж, эмчийн заавраар жороор эм авч хэрэглэх хэрэгтэй. Эмийг хэтрүүлэн хэрэглэх нь маш хор уршигтай байдаг.

Насны байдал	2017 он	2018 он	2019 -9 сар
14 нас	-	1	1
15 нас	1	1	3
16 нас	8	6	3
17 нас	18	21	13
18 нас	28	44	27
19 нас	53	48	39
Нийт	108	121	86


Өсвөр насны төрөлт

Өсвөр насны буюу 14-19 насандаа жирэмсэлж төрсөн охидын тоог 2018 оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Үр хөндөлт
/бодит тоогоор/

Нийт үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 23 хувийг 20 хүртэлх насны охид эзэлж байна.


Үзүүлэлт	2017 он	2018 он	2019-9 сар
Нийт үр хөндөлт	210	216	46
Хожуу үр хөндөлт	13	17	8
20 хүртэлх нас	20	19	2



Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүүхдийн эзлэх хувь


Нийт эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 24,3-25,5%-ийг 0-18 насны хүүхэд эзэлж байна.

2017-2019 онд осол гэмтэлд өртсөн хүүхдийн эзлэх хувь /сумдаар/



Сүүлийн 3 жилийн байдлаар осол гэмтэлд **1168** хүүхэд өртсөний **273** хүүхэд нь Хэрлэн сумын хүүхдүүд байна.

3 жилийн дунджаар нийт түлэгдэлтэнд хүүхдийн эзлэх хувь /сумдаар/



Сүүлийн 3 жилийн дунджаар нийт 194 хүүхэд түлэгдсэний 54 хүүхэд нь Хэрлэн сумын хүүхдүүд байна.

Насны байдал	2017 он	2018 он	2019 -9 сар
14 нас	1	-	-
15 нас	-	1	3
16 нас	11	11	1
17 нас	21	6	5
18 нас	5	12	7
19 нас	15	12	6
Нийт	53	42	22

Өсвөр насны хүүхдийн БЗДХ-ын өвчлөл

БЗДХ-аар өвчилсөн өсвөр насны хүний тоо сүүлийн 3 жилийн байдлаар буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч нийт 14-19 насны хүүхдүүдийн **250** хүүхэд тутмын **1** нь БЗДХ-аар өвчилж байна.

Хүүхэд бүр сурч хөгжих эрхтэй




ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ /28-р зүйл/

Оролцогч улсууд хүүхдийн сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, энэ эрхийг тэгш боломжийн үндсэн дээр аажмаар хэрэгжүүлэхийн тулд дараахь арга хэмжээ авна:

- (a) бага боловсролыг үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэх;
- (b) дунд боловсролын олон хэлбэр, түүний дотор ерөнхий болон мэргэжлийн боловсролыг хүүхэд бүрт хүртээмжтэй болгох, хөгжүүлэх, шаардлагатай тохиолдолд санхүүгийн тусламж үзүүлэх буюу үнэ төлбөргүй боловсрол олгох;
- (c) хүн бүр чадвартаа түшиглэн дээд боловсрол эзэмших бололцоог шаардлагатай бүх арга замаар хангах;
- (d) боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгох талаархи мэдээллийг хүүхэд бүрт хүртээмжтэй болгох;
- (e) хүүхдийн хичээлийн оролцоог тогтмолжуулах болон сургууль завсардалтын түвшинг бууруулах.


ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН ТОО

/ Бага, дунд, ахлах /




Аймгийн хэмжээнд бага болон ахлах ангийн сурагчдын тоо тус бүр өссөн ба, суурь боловсрол эзэмшигч сурагчдын тоо өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

ДОТУУР БАЙРАНД АМЬДАРЧ БАЙГАА СУРАГЧДЫН ТОО



Дотуур байранд амьдрах сурагчдын тоо жил бүр буурч байгаа ба нийт суралцагчдын 8,4 хувь нь гэр бүлээсээ тусдаа дотуур байранд амьдран суралцаж байна.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХҮҮХДИЙН ХАМРАГДАЛТ



Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь 2017-2018 оны хичээлийн жилд 90,5%, 2018-2019 оны хичээлийн жилд 89,8 хувь, 2019-2020 оны хичээлийн жилд 85,0 хувь болж буурсан.


БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2017-2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Үүнд улсын төсөв, БСУГ, өөрийн хөрөнгө, хандив тусламж, орон нутгийн хөгжлийн сан болон олон улсын төсөлт хөтөлбөрийн хөрөнгө оруулалт тус тус багтсан болно.



СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН ХҮҮХДИЙН ТОО



Хүүхэд бүр хамгаалуулах эрхтэй



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ /19-р зүйл/


1. Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.

2. Хамгаалалтын ийм арга хэмжээ нь хүүхэд, тэднийг асран халамжилдаг хүмүүст шаардлагатай тусламжийг үзүүлэх зорилгоор нийгмийн хөтөлбөр боловсруулах, түүнчлэн хүүхдэд хэрцгийгээр хандахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, авч хэлэлцэхээр шилжүүлэх, мөрдөн байцаалт явуулах, эмчлэх, шаардлагатай тохиолдолд шүүх ажиллагаа явуулах болон бусад арга хэмжээг тусгасан журмыг агуулна.

ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДИЙН ТОО




ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО



Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо гэдэг нь хүчирхийлэлд өртсөн нь илэрч мэдээлэгдсэн хүүхдийн тоог илэрхийлнэ. Энэ нь ГБХЗХГ-т хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлэгдэн үйлчилгээ авсан хүүхдүүдийн тоо болно.

ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО




Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо гэдэг нь хүчирхийлэлд өртсөн нь илэрч мэдээлэгдсэн хүүхдийн тоог илэрхийлнэ. Энэ нь ГБХЗХГ-т хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлэгдэн үйлчилгээ авсан хүүхдүүдийн тоо болно.

ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХЭД

Хурдан морины уралдаанд 7-16 насны хүүхдүүд хурдан морь унаж уралдаж байгаа ба 4 жилийн дунджаар тухайн насны хүүхдүүдийн 8,7% нь хурдны морь унаж байгаа ба, нийт уралдаанч хүүхдийн 17 орчим хувийг охид эзэлж байна.



Эрх нь зөрчигдсэн, хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо



Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоо



2018 онд нийт хүүхдийн 4,5% нь дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхөд амьдарч байна.

Гэмт хэрэгт холбогдсон болон Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авсан хүүхдийн харьцуулалт



Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь Хүүхэд хамгааллын хуульд заасан чиг үүргийнхээ дагуу ажиллаж байгаа ба зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүхээр ял шийтгэгдсэн хүүхдүүдээс гадна эрх нь зөрчигдсэн хохирогч гэрч хүүхдүүдэд мөн адил үйлчилгээ үзүүлнэ.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авсан хохирогч хүүхдийн мэдээлэл

2019 оны 3-р улирлын байдлаар

- ▶ Хууль зүйн хорооны хяналтад авсан-32
- ▶ Хохирогч охид-8
 - -бэлгийн хүчирхийллийн хохирогч-5
 - -гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэрч-3
 - -өсвөр насны хүнтэй бэлгийн харьцаанд орсон гэмт хэргийн хохирогч-1

Хохирогч хамгаалах байр, НЦҮТ-өөр үйлчлүүлэгчид

Хамгаалалтын үйлчилгээнд хамрагдсан охид-5

Хүүхдийн утас 108-д ирсэн дуудлага

ОН	Ирсэн дуудлага	Агуулга	Шийдвэрлэлт
2018	70	Харъяалал андуурсан 2, үндсэн 68 дуудлага байна. Дээрх ирсэн дуудлага мэдээллийн 28 эрэгтэй хүүхэд, 39 эмэгтэй хүүхэдтэй холбоотой мэдээлэл ирсэн байна. Бие махбодийн хүчирхийлэлд өртсөн -10 Сургууль болон Багшийн ёс зүйтэй холбоотой асуудал -15 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн -8 Орхигдсон, үл хайхрагдсан -19 Осол аваарт орсон -1 Хүүхдийн эрхийн зөрчил - 5 Эцэг эх нь архидан согтуурсан -4 Гэрээсээ дайжсан-3 Нас барсан 3 Очих газаргүй -2	Хүүхдийн эрхийн улсын байцаагч зөрчлийг шалгаж шийдвэрлэж арга хэмжээ авсан 2 Хамтарсан багт мэдээллийг шилжүүлсэн, хамтарч ажилласан 12 Зөвлөгөө өгсөн 9 Нөхцөл байдлыг үнэлсэн 13 Шаардлагатай үйлчилгээ, холбогдох байгууллагад холбон зуучилсан 6 Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн 13 Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн 6 Зөрчлийн шинжтэй хэргийг ХЭУБ харъяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн 1 Шаардлагатай үйлчилгээ үзүүлж 32 кейсийг хаасан, 26 кейсийг манай байгууллагын зүгээс давхар хяналтанд байна.
2019 оны эхний 10 сар	30	Бие махбодийн хүчирхийлэлд өртсөн- 10 Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн- 2 Гэрээсээ дайжсан- 1 Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн- 3 Эцэг эх нь гэр бүлийн зөрчилтэй-2 Эцэг эх нь архидан согтуурсан-1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн- 3 Багшийн ёс зүйтэй холбоотой асуудал- 8	Хүүхдийн эрхийн улсын байцаагч зөрчлийг шалгаж шийдвэрлэж арга хэмжээ авсан 2 Хамтарсан багт мэдээллийг шилжүүлсэн, хамтарч ажилласан 12 Зөвлөгөө өгсөн 2 Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн 9 Цагдаагийн байгууллагад мэдээллэж, шилжүүлсэн 6 Сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн 4 Зөрчлийн шинжтэй хэргийг ХЭУБ харъяаллын дагуу цагдаа, прокурорт шилжүүлсэн 1 Нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулан үйлчилгээ үзүүлсэн- 5

Хамгаалах байранд хандсан кейсийн тоо:

№	Он	Хамгаалах байрны төсөв	Нийт хандсан кейс	Хамгаалах байранд байрласан нь
1	2014	8.794.136	15	4
2	2015	7.385.958	17	9
3	2016	6.674.000	33	9
4	2017	6.874.000	39	13
5	2018	7,709,815	23 кейсийн 52	14
	нийт дүн	37.437.909	127 кейсийн 313 хүүхэд эмэгтэйчүүдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	49 кейсийг байрлуулан үйлчилгээ хүргээд байна.

Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ /13-р зүйл/


1. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, хэвлэмэл буюу урлагийн бүтээлийн хэлбэрээр, хүүхдийн сонгосон мэдээллийн бусад арга хэрэгслээр эрэх, олж авах, дамжуулах эрх чөлөөг багтаана.

2. Энэ эрхийг хэрэгжүүлэхэд зарим хязгаарлалт тогтоож болох бөгөөд энэ нь хуульд зааснаар:

(a) бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх;


(b) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахад шаардлагатай байвал зохино.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зарчимд нийцсэн ИТХ-ын тогтоол, ЗД-ын захирамж



Тухайн жилд гарч байгаа ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийн 3 хувь нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зарчимд нийцсэн байна.

Хүүхдээс гарсан саналыг шийдвэртээ тусгасан ИТХ-ын тогтоол




Хүүхдийн чуулган, хэлэлцүүлэг, өдөрлөгөөс гаргасан саналыг тусгаж гарсан ИТХ-ын тогтоолыг хэлнэ.

Хурал нь тогтмолжсон Хүүхдийн төлөө зөвлөл



Хэнтий аймгийн 18 суманд Хүүхдийн төлөө зөвлөл ажиллаж байгаа ба тухайн жилд хуралдсан хурлуудаас 75%-аас дээш ирцтэй хурал нь 2013, 2014, 2018 онуудад хамгийн өндөр буюу 53-58 хурал 75-аас дээш хувийн ирцтэй хуралджээ

Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллага



ТЭМДЭГЛЭЛ